

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/101/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: adiyasurenb@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн:

Уваа уул аудит ХХК, захирал: Ч.Мөнхтуяа

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2026.02.25 № 01/197
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Т.МӨНХТУЯА
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 254 дүгээр тогтоолоор Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн хүүхдийн нэг өдрийн үдийн хоолны түүхий эдийн зардлыг 2.5 мянган төгрөг, дотуур байранд амьдрах дунд болон ахлах ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6.3 мянган төгрөг, бага ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон байна.

Аудитын гол асуудал

Төв аймгийн Засаг даргын Тамгын газраас хэрэгжүүлж буй “Багийн бага сургууль” төслийн хүрээнд Боловсролын яам, Нэгдсэн Үндэсний байгууллагын “Хүүхдийн сан”, “Хаан банк”-ны хамтарсан дэмжлэгээр 1,423,432.3 мянган төгрөгийн Үдлэг дөрөвдүгээр багийн төвд бага сургуулийг ашиглалтад оруулсан.

Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Засаг даргын Тамгын газраас орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Хүүхдийн автобус хөтөлбөр”-ын хүрээнд ТӨАХААГ/20240102068


4126020183

Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

дугаартай худалдан авах ажиллагааг зохион байгуулж, "Хаштехник" ХХК шалгарч нэг бүр нь 57,497.0 мянган төгрөгийн өртөгтэй БНХАУ-д үйлдвэрлэсэн хүүхдийн шар автобусыг 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдөр хүлээлгэн өгсөн байна.

Хүүхдийн шар автобусны суудлын хэмжээ нь бага ангийн сурагч суух боломжгүй жижиг, техникийн шаардлага хангахгүй, эвдрэлтэй байсан тул Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургууль хүлээн авснаас хойш замын хөдөлгөөнд оролцоогүй байна.

Тус байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт бүхий нийт 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 97,9 хувиар үнэлэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	775,100,483.61	508,112,026.17
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	546,580,375.83	250,289,914.65
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	546,580,375.83	250,289,914.65
3121	Төгрөг	546,580,375.83	250,289,914.65
31211	Төрийн сангийн харилцах	546,580,375.83	250,289,914.65
33	АВЛАГА	1,748,261.59	3,102,606.55
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,748,261.59	3,102,606.55
35	БАРАА МАТЕРИАЛ	226,771,846.19	254,719,504.97
354	Хангамжийн материал	226,771,846.19	254,719,504.97
35410	Бичиг хэргийн материал	1,123,215.00	1,034,280.00
35420	Аж ахуйн материал	18,500.00	22,000.00
35440	Түлш, шатах тослох материал	6,110,000.00	-
35460	Хүнсний материал	153,467.30	256,017.30
35470	Бусад хангамжийн материал	219,366,663.89	253,407,207.67
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	16,730,085,624.79	18,261,202,905.48
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	16,730,085,624.79	18,261,202,905.48
392	Биет хөрөнгө	16,606,904,321.94	18,138,841,927.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	16,588,994,310.19	18,047,272,882.03
39202	Хуримтлагдсан элэгдэл	(978,690,730.73)	(1,055,398,513.46)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	210,210,654.80	210,210,654.80
39204	Хуримтлагдсан элэгдэл	(29,953,238.19)	(45,674,888.28)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	676,484,241.27	828,623,460.27
39206	Хуримтлагдсан элэгдэл	(179,602,242.21)	(221,237,272.24)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	524,104,020.26	624,719,085.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	(258,221,924.23)	(301,184,251.61)
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,998,025.00	20,998,025.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,808,069.20)	(5,876,528.94)
39217	Ном	36,389,274.98	36,389,274.98
393	Биет бус хөрөнгө	123,181,302.85	122,360,977.87
39301	Программ хангамж	2,406,300.00	2,406,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(236,997.15)	(1,057,322.13)
39303	Бусад биет бус хөрөнгө	121,012,000.00	121,012,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	17,505,186,108.40	18,769,314,931.65
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	49,949,473.47	57,676,083.05
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	49,949,473.47	57,676,083.05
413	Өглөг	49,949,473.47	57,676,083.05
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	15,330,918.78	503,236.36
4136	Бусад өглөг	34,618,554.69	57,172,846.69
41361	Байгууллагад төлөх өглөг	33,106,000.00	54,416,092.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,512,554.69	2,756,754.69
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	17,455,236,634.93	18,711,638,848.60

**Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

51	Засгийн газрын хувь оролцоо	1,008,954,216.48	1,008,954,216.48
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,008,954,216.48	1,008,954,216.48
51101	Өмч: - төрийн	1,008,954,216.48	1,008,954,216.48
512	Хуримтлагдсан үр дүн	14,332,105,479.31	15,658,853,405.50
51210	Өмнөх үеийн үр дүн	14,332,105,479.31	14,402,451,182.98
51220	Тайлант үеийн үр дүн		1,256,402,222.52
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,114,176,939.14	2,043,831,226.62
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	17,505,186,108.40	18,769,314,931.65

Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,888,971,325.00	7,263,904,848.14
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,513,325.00	1,822,639,148.14
120	Нийтлэг татварын бус орлого	2,513,325.00	1,822,639,148.14
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,513,325.00	1,822,639,148.14
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,976,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,513,325.00	14,542,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө		1,762,592,984.36
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-бараа материал		41,527,963.78
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,886,458,000.00	5,441,265,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,300,821,800.00	4,970,640,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,300,821,800.00	4,970,640,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	585,636,200.00	470,625,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	585,636,200.00	470,625,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,870,345,239.17	5,964,355,636.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,870,345,239.17	5,964,355,636.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,571,039,874.93	5,698,804,473.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,088,694,616.84	3,904,724,458.74
210101	Үндсэн цалин	1,747,924,545.91	2,297,413,663.74
210102	Нэмэгдэл	1,262,407,761.93	1,440,185,703.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	13,925,000.00
210104	Урамшуулал	78,362,309.00	153,200,092.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	374,558,939.27	527,439,345.75
210201	Тэтгэврийн даатгал	259,750,239.73	368,384,730.15
210202	Тэтгэмжийн даатгал	31,417,891.86	39,794,083.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,320,158.03	21,945,107.43
210204	Ажилгүйдлийн даатгал	14,829,271.20	20,610,851.94
210205	Эрүүл мэндийн даатгал	54,241,378.45	76,704,573.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	493,013,400.47	462,564,897.05
210301	Гэрэл, цахилгаан	41,286,738.29	139,685,823.98
210302	Түлш, халаалт	438,976,662.18	306,879,073.07
210303	Цэвэр, бохир ус	12,750,000.00	16,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,301,249.00	68,723,190.00
210401	Бичиг хэрэг	22,645,549.00	18,597,037.00
210402	Тээвэр, шатахуун	6,955,600.00	15,319,043.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,700,100.00	34,807,110.00
2105	Нормативт зардал	299,990,188.15	353,996,240.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	500,000.00	-
210502	Хоол, хүнс	258,993,718.15	353,996,240.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	40,496,470.00	-

**Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,110,000.00
210604	Урсгал засвар	-	1,110,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	7,650,000.00
210702	Дотоод албан томилолт	-	7,650,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,098,155.93	46,611,987.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	3,976,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	46,098,155.93	42,635,787.04
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	231,383,325.27	325,984,355.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	51,210,150.91	53,138,624.42
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,876,800.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	167,296,374.36	272,845,730.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	299,305,364.24	265,551,162.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	211,492,550.32	256,381,060.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	161,722,150.00	256,381,060.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	49,770,400.32	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	87,812,813.92	9,170,102.95
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	87,812,813.92	9,170,102.95
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	18,626,085.83	1,299,549,211.31
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	43,146,988.79
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		43,146,988.79
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(43,146,988.79)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	18,626,085.83	1,256,402,222.52

Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,888,971,325.00	5,459,783,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,513,325.00	18,518,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,513,325.00	18,518,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,513,325.00	18,518,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,976,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,513,325.00	14,542,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,886,458,000.00	5,441,265,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,300,821,800.00	4,970,640,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,300,821,800.00	4,970,640,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	585,636,200.00	470,625,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	585,636,200.00	470,625,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,746,649,288.13	5,678,792,361.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,746,649,288.13	5,678,792,361.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,440,772,377.21	5,426,333,958.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,060,521,270.75	3,966,784,194.55
210101	Үндсэн цалин	1,926,022,578.34	2,340,652,448.87
210102	Нэмэгдэл	985,382,328.92	1,457,134,060.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	13,909,884.00
210104	Урамшуулал	149,116,363.49	155,087,801.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	389,246,360.28	480,556,446.17
210201	Тэтгэврийн даатгал	266,268,756.06	335,733,592.44
210202	Тэтгэмжийн даатгал	31,749,730.05	38,419,241.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,582,978.03	18,575,755.15
210204	Ажилгүйдлийн даатгал	15,177,811.01	17,460,180.64
210205	Эрүүл мэндийн даатгал	60,467,085.13	70,367,676.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	491,823,386.08	456,454,897.05
210301	Гэрэл, цахилгаан	32,668,000.00	108,147,397.05
210302	Түлш, халаалт	446,405,386.08	332,307,500.00
210303	Цэвэр, бохир ус	12,750,000.00	16,000,000.00
2105	Нормативт зардал	255,130,361.55	354,556,500.00
210502	Хоол, хүнс	255,130,361.55	354,556,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	6,000,000.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	64,342,755.93	61,262,487.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	3,976,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	64,342,755.93	57,286,287.04
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	173,708,242.62	101,719,433.42

**Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	143,089,173.62	81,474,933.42
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,619,069.00	20,244,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	305,876,910.92	252,458,402.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	218,064,097.00	243,288,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	168,293,700.00	243,288,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	49,770,397.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	87,812,813.92	9,170,102.95
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	87,812,813.92	9,170,102.95
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	142,322,036.87	(219,008,461.18)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	79,752,599.38	77,282,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	79,752,599.38	77,282,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	79,752,599.38	77,282,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	79,752,599.38	77,282,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(79,752,599.38)	(77,282,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	62,569,437.49	(296,290,461.18)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		546,580,375.83
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	546,580,375.83	250,289,914.65

Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,008,954,216.48	2,114,176,939.14	2,768,326,638.21	5,891,457,793.83
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,008,954,216.48	2,114,176,939.14	2,768,326,638.21	5,891,457,793.83
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	11,563,778,832.25	11,563,778,832.25
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,008,954,216.48	2,114,176,939.14	14,332,105,470.46	17,455,236,626.08
2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,008,954,216.48	2,114,176,939.14	14,332,105,470.46	17,455,236,626.08
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	70,345,712.52	70,345,712.52
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,008,954,216.48	2,114,176,939.14	14,402,451,182.98	17,525,582,338.60
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(70,345,712.52)	-	(70,345,712.52)
Тайлант үеийн үр дүн	-	-	1,256,402,222.52	1,256,402,222.52
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,008,954,216.48	2,043,831,226.62	15,658,853,405.50	18,711,638,848.60

Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,122,579,400.00	5,450,613,797.05	671,965,602.95	89.02
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,106,135,600.00	4,970,640,700.00	135,494,900.00	97.35
131001	Улсын төсвөөс санхүүжих	5,106,135,600.00	4,970,640,700.00	135,494,900.00	97.35
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	465,775,900.00	461,454,897.05	4,321,002.95	99.07
132001	Орон нутгийн төсвөөс	465,775,900.00	461,454,897.05	4,321,002.95	99.07
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	550,667,900.00	18,518,200.00	532,149,700.00	3.36
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,211,200.00	18,518,200.00	693,000.00	96.39
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	531,456,700.00		531,456,700.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,122,579,400.00	5,746,904,258.23	375,675,141.77	93.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,122,579,400.00	5,746,904,258.23	375,675,141.77	93.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,866,472,200.00	5,503,615,958.23	362,856,241.77	93.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,225,974,300.00	3,966,784,194.55	259,190,105.45	93.87
210101	Үндсэн цалин	2,623,045,300.00	2,340,652,448.87	282,392,851.13	89.23
210102	Нэмэгдэл	1,468,981,300.00	1,457,134,060.00	11,847,240.00	99.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	13,909,884.00	(13,909,884.00)	
210104	Урамшуулал	133,947,700.00	155,087,801.68	(21,140,101.68)	115.78
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	528,247,100.00	480,556,446.17	47,690,653.83	90.97
210201	Тэтгэврийн даатгал	359,207,900.00	335,733,592.44	23,474,307.56	93.46
210202	Тэтгэмжийн даатгал	42,259,700.00	38,419,241.06	3,840,458.94	90.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,130,000.00	18,575,755.15	2,554,244.85	87.91
210204	Ажилгүйдлийн даатгал	21,130,000.00	17,460,180.64	3,669,819.36	82.63
210205	Эрүүл мэндийн даатгал	84,519,500.00	70,367,676.88	14,151,823.12	83.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	460,775,900.00	456,454,897.05	4,321,002.95	99.06
210301	Гэрэл, цахилгаан	112,468,400.00	108,147,397.05	4,321,002.95	96.16
210302	Түлш, халаалт	332,307,500.00	332,307,500.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	16,000,000.00	16,000,000.00	-	100.00
2105	Нормативт зардал	392,360,900.00	354,556,500.00	37,804,400.00	90.36
210502	Хоол, хүнс	392,360,900.00	354,556,500.00	37,804,400.00	90.36
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	72,357,400.00	61,262,487.04	11,094,912.96	84.67
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,976,200.00	3,976,200.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	68,381,200.00	57,286,287.04	11,094,912.96	83.77
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	181,756,600.00	179,001,433.42	2,755,166.58	98.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	161,331,100.00	158,756,933.42	2,574,166.58	98.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,425,500.00	20,244,500.00	181,000.00	99.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	256,107,200.00	243,288,300.00	12,818,900.00	94.99

**Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2132	Бусад урсгал шилжүүлэг	256,107,200.00	243,288,300.00	12,818,900.00	94.99
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	256,107,200.00	243,288,300.00	12,818,900.00	94.99
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		546,580,375.83		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		250,289,914.65		

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 4,154,136.4 мянган төгрөгийн алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Санхүүгийн байдлын тайланд тайлант оны үр дүнг 1,177,625.3 мянган төгрөгөөр, санхүүгийн үр дүнгийн тайланд (192.048.7) мянган төгрөгөөр тайлагнаж, 1,369.674.0 мянган төгрөгөөр зөрүүтэй толилуулсан байна.

Санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээний тайланд урсгал санхүүжилтийг 510,288.3 мянган төгрөгөөр дутуу, орон нутгийн санхүүжилтийг 512,696.3 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.

Санхүүгийн үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайланд заалны орлого, номын түрээсийн 14,449.0 мянган төгрөгийн орлогыг бөөн дүнгээр бүртгэсэн.

Санхүүгийн мөнгөн гүйлгээний тайланд цэвэр бохир усны зардлыг 3,000.0 мянган төгрөг, бусад зардлыг 16,011.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнаж, нийт цэвэр мөнгөн гүйлгээний дүн зөрүүтэй, худалдан авсан 77,282.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг биет ба бус хөрөнгө худалдан авах зардалд тайлагнаагүй байна.

Санхүүгийн байдлын тайланд 2,300.00 мянган төгрөгийн хөргөгчийг газар дансанд буруу тайлагнасан.

Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 8,280.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хүүгийн орлогоор тайлагнасан.

Санхүүгийн үр дүнгийн тайланд 2,899.4 мянган төгрөгийн бичиг хэргийн зардлыг үндсэн цалингийн зардалд, 11,738.1 мянган төгрөгийг бичиг хэргийн зардал, 25,122.2 мянган төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардлыг тус тус бусад зардалд, 6,990.0 мянган төгрөгийн албан томилолтын зардлыг хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд тайлагнасан байна.

Харилцагч байгууллагаас 233.0 мянган төгрөгийн худалдан авсан бичиг хэргийн материал, Хулангийн хишиг ХХК-аас 1,697.7 мянган төгрөгийн аж ахуйн материал бараа материалын дансанд орлогод авч шаардах хуудсаар зарлагдаагүй шууд зардалд тайлагнасан.

Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төсвийг 1,575,911.7 мянган төгрөгөөр дутуу бүртгэж, төсвийн тохируулгын бичилт хийгээгүй бүртгэснийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна”, 15.2-т “нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасны дагуу санхүүгийн тайланд залруулга хийсэн.

Аудитаар нийт 12,625.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй 1 албан шаардлага, 12,625.6 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 12,625.6 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 59,643.5 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 911 ширхэг 273,748.8 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, холбогдох байгууллагад хүсэлт өгч шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” тухай 271 дүгээр тогтоолын 7.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын

Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ”, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох саналыг Төв аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх албан шаардлага өгөв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5-д "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3-д "Санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана" гэж заасантай тус тус нийцэхгүй, "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг тайлбар тодруулгын хамт бэлтгэж байх.

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацаанд 1 ажилтанд олгосон хөдөлмөрийн чадвараа алдсаны 508.0 мянган төгрөгийн тэтгэмжийг ажил олгогчоос олгох Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас олгосон.

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэлийн хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2021 оны "Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай" 190 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилалд ашиглах заавар"-тай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвөөс зардал гаргахдаа Сангийн сайдын баталсан эдийн засгийн ангилал ашиглах зааврыг ашиглан давтан гаргахгүй ажиллах.

3. Зардлын данстай асуудалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацаанд 1 иргэнээр архивын баримт цэгцлүүлэх ажлыг 3,000.0 мянган төгрөгөөр хийлгэж батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг, бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-т "хариуцлагатай байх" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын батлагдсан орон тоонд архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтантай тул архивын ажил хийлгэх гэрээт ажилтан авч ажиллуулах зөрчлийг давтан гаргахгүй ажиллах.

4. Зардлын данстай асуудалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хүүхэд хамгааллын (80233) хөтөлбөрийн бараа үйлчилгээний бусад зардлаас 6,315.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Эдийн засгийн ангилал ашиглах заавар", Боловсролын сайдын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн "Заавар шинэчлэн батлах тухай" А/279 дүгээр тушаалаар баталсан "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд шаардлагатай сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"-ын 3.1-т "Тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг Хүүхдэд ээлтэй сургалтын орчин зориулалтын (81816) хөтөлбөрийн бараа үйлчилгээний бусад зардал (210901)-эдийн засгийн ангилалд төлөвлөн хуваарилж, санхүүжүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хүүхдэд ээлтэй сургалтын орчин зориулалтын хөтөлбөрөөс үндсэн хөрөнгө бэлтгэх, бусад хөтөлбөрөөс үндсэн хөрөнгө бэлтгэхгүй байх зөрчлийг давтан гаргахгүй ажиллах.

5. Авлагын данстай асуудалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Өмнөх оны 1,748.3 мянган төгрөгийг бүрэн барагдуулаагүй, тайланд онд 2 ажилтанд 1,354.3 мянган төгрөгийн илүү цалин бодон олгож, 3,102.6 мянган төгрөгийн авлагатай тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үүссэн авлагыг бүрэн барагдуулах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 20-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн байдлын тайланд тайлант оны үр дүнг 1,177,625.3 мянган төгрөгөөр, санхүүгийн үр дүнгийн тайланд (192.048.7) мянган төгрөгөөр тайлагнаж, 1.369.674.0 мянган төгрөгөөр зөрүүтэй толилуулсан байна.	1	1,369,674.1			1	1,369,674.1	1	1,369,674.1		
2	Санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээний тайланд урсгал санхүүжилтийг 510,288.3 мянган төгрөгөөр дутуу, орон нутгийн санхүүжилтийг 512,696.3 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.	1	1,022,984.6			1	1,022,984.6	1	1,022,984.6		
3	Санхүүгийн үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайланд заалны орлого, номын түрээсийн 14,449.0 мянган төгрөгийн орлогыг бөөн дүнгээр бүртгэсэн.	1	14,449.0			1	14,449.0	1	14,449.0		
4	Санхүүгийн мөнгөн гүйлгээний тайланд цэвэр бохир усны зардлыг 3,000.0 мянган төгрөг, бусад зардлыг 16,011.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнаж, нийт цэвэр мөнгөн гүйлгээний дүн зөрүүтэй, худалдан авсан 77,282.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг биет ба бус хөрөнгө худалдан авах зардалд тайлагнаагүй байна.	1	96,293.2			1	96,293.2	1	96,293.2		
5	Санхүүгийн байдлын тайланд 2,300.00 мянган төгрөгийн хөргөгчийг газар дансанд буруу тайлагнасан.	1	2,300.0			1	2,300.0	1	2,300.0		
6	Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 8,280.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хүүгийн орлогоор тайлагнасан.	1	8,280.0			1	8,280.0	1	8,280.0		
7	Санхүүгийн үр дүнгийн тайланд 2,899.4 мянган төгрөгийн бичиг хэргийн зардлыг үндсэн цалингийн зардалд, 11,738.1 мянган төгрөгийг бичиг хэргийн зардал, 25,122.2 мянган төгрөгийн бага үнэтэй түргэн	1	62,313.2			1	62,313.2	1	62,313.2		

Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	элэгдэх зүйлийн зардлыг тус тус бусад зардалд, 6,990.0 мянган төгрөгийн албан томилолтын зардлыг хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд тайлагнасан байна.									
8	Харилцагч байгууллагаас 233.0 мянган төгрөгийн худалдан авсан бичиг хэргийн материал, Хулангийн хишиг ХХК-аас 1,697.7 мянган төгрөгийн аж ахуйн материал бараа материалын дансанд орлогод авч шаардах хуудсаар зарлагдаагүй шууд зардалд тайлагнасан.	1	1,930.7			1	1,930.7	1	1,930.7	
9	Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төсвийг 1,575,911.7 мянган төгрөгөөр дутуу бүртгэж, төсвийн тохируулгын бичилт хийгээгүй.	1	1,575,911.7			1	1,575,911.7	1	1,575,911.7	
	Дүн	9	4,154,136.4			9	4,154,136.4	9	4,154,136.4	

Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайлан хугацаанд 1 ажилтанд олгосон хөдөлмөрийн чадвараа алдсаны 508.0 мянган төгрөгийн тэтгэмжийг ажил олгогчоос олгох Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас олгосон.	1	508.0					1	508.0				
2	Тайлант хугацаанд 1 иргэнээр архивын баримт цэгцлүүлэх ажлыг 3,000.0 мянган төгрөгөөр хийлгэж батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	3,000.0					1	3,000.0				
3	Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 911 ширхэг 273,748.8 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, холбогдох байгууллагад хүсэлт өгч шийдвэрлүүлээгүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.	1				1							
4	Хүүхэд хамгааллын (80233) хөтөлбөрийн бараа үйлчилгээний бусад зардлаас 6,315.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн..	1	6,315.0					1	6,315.0				
5	Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.	1						1					
6	Өмнөх оны 1,748.3 мянган төгрөгийг бүрэн барагдуулаагүй, тайланд онд 2 ажилтанд 1,354.3 мянган төгрөгийн илүү цалин бодон олгож, 3,102.6 мянган төгрөгийн авлагатай тайлагнасан.	1	3,102.6					1	3,102.6				
	Дүн	6	12,925.6			1		6	12,925.6				

Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 114 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 28 мэдээлэл, байршуулаагүй 29 байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас орлогын 3,314,306.6 мянган төгрөгийн 46 гүйлгээ, зарлагын 887,918.4 мянган төгрөгийн 54 гүйлгээ хугацаа хоцорч, орлогын 1,044,101.5 мянган төгрөгийн 20 гүйлгээ, зарлагын 136,270.3 мянган төгрөгийн 7 гүйлгээ байршуулаагүй. Мөн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаягийн 675,126.8 мянган төгрөг болон шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэр эх хуулбар, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, аудитын тайлан дүгнэлт, зөвлөмжийн мөрөө авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан тус тус байршуулаагүй байна.	1	5,482,596.8			1	5,482,596.8		-
Дүн	1	5,482,596.8			1	5,482,596.8		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Нийт 59,500.0 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмж, 25,07.0 мянган төгрөгийн тавилга эд хогшлын худалдан авалт хийхдээ тендер зарлаагүй шууд худалдан авалт хийсэн.	1	84,517.0					1	84,517.0
Дүн	1	84,517.0					1	84,517.0
Нийт дүн	1	5,567,113.8			1	5,482,596.8	1	84,517.0

Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 65-20810579-ТӨА-2026/101/НА-СТА-ТШЗ

Зуунмод сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 114 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 28 мэдээлэл, байршуулаагүй 29 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас орлогын 3,314,306.6 мянган төгрөгийн 46 гүйлгээ, зарлагын 887,918.4 мянган төгрөгийн 54 гүйлгээ хугацаа хоцорч, орлогын 1,044,101.5 мянган төгрөгийн 20 гүйлгээ, зарлагын 136,270.3 мянган төгрөгийн 7 гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаягийн 675,126.8 мянган төгрөг, шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэр эх хуулбар, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, аудитын тайлан дүгнэлт, зөвлөмжийн мөрөө авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг тус тус байршуулаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “хариуцлагатай байх”, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1.5-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.10-т “Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-т “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь үнэн зөв байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Т.Мөнхтуяа, нягтлан бодогч Ш.Алмабек нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.МӨНХТУЯА





ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 64-20810579-ТӨА-2026/101/НА-СТА-ТШЗ

Зуунмод сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 911 ширхэг 273,748.8 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, холбогдох байгууллагад хүсэлт өгч шийдвэрлүүлээгүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “хариуцлагатай байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.7 “нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” тухай тогтоолын 7.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-т “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үндсэн хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох ажлыг зохион байгуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Т.Мөнхтуяа, нягтлан бодогч Ш.Алмабек нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.МӨНХТУЯА

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn